

“Тэс” адууны эдийн засгийн ашиг

Зандангийн Ядмаа* 

Эдийн засаг, бизнесийн сургууль, ХААИС, Зайсан 17024, Улаанбаатар

*Холбоо баригч зохиогч: yadmaa.z@muls.edu.mn

 <https://orcid.org/0000-0002-8374-5555>

Хүлээн авсан: 01.10.2021

Хянасан: 07.12.2021

Хэвлэлтэд орсон: 31.12.2021

Хураангуй

Тэс угшлын адууны 1 толгойгоос олж байгаа ашигт ажиллагааны төвшин 67% байгаа нь Монгол үүлдрийн адууныхаас 10%-иар илүү, Галшар үүлдрийн адууныхтай ижил төвшинд байна. Байгалийн эрс тэс уур амьсгалтай газар нутагт дасан зохицох чадвар өндөр тул уналга эдэлгээ, усч, тэсвэр тэвчээрээр илүү, өвчлөл бага байгаа нь өрхий аж ахуйн хувьд өндөр ач холбогдолтой. Үүнийг нийт судалгаанд хамрагдсан малчдын 96% нь хариулсан байна. Мөн адууны зүй бус хорогдол, гүүний хээл хаялт бага байгаа нь тухайн газар нутагт дасан зохицсон, өрхийн орлогын хувьд тогтвортой аж ахуй болох нь харагдаж байна.

Түлхүүр үг: үүлдэр, орлого, зарлага, Галшар

Оршил

Адууны аж ахуйн хувьд эдийн засгийн ашгийг тооцоолоход хүнсний хэрэгцээг хангах мах, сүү хөнгөн үйлдвэрийн салбарын түүхий эдийн хэрэгцээг хангах арьс шир, дэл, сүүл, хөөвөр, яс, туурай эмчилгээ гоо сайхны бүтээгдэхүүн өөх тос, саам, гүүний эхэс, нийгэм соёлын бүтээгдэхүүн болох уналга, ачлага, хурдны болон хатирга, жороо морины уралдаан, зэрэг ашиг орлогыг тооцоолох шаардлагатай. Нөгөө талаас адууг эдэлж хэрэглэхэд шаардагдах гэжээлийн болон хариуллага маллагааны бусад зардлуудыг тооцолж тухайн хувь хүн өрхийн аж ахуйн эдийн засгийн өгөөжийг гаргах ёстой. 1960 оноос эхлэн тухайн үеийн улс, аймаг орон нутгийн удирдлагууд, мэргэжилтнүүд адууны аж ахуйг хөгжүүлэх, түүний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, үржлийн зорилгоор худалдаалах, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бусад аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон ажлууд санаачлан хэрэгжүүлж байсны тодорхой жишээ нь Завхан аймаг, Увс аймагт хэрэгжүүлсэн Тэс адууны аж ахуйн чиглэлээр хийж, хэрэгжүүлсэн ажлуудаас харагддаг. Тухайлбал 1972 онд Завхан аймагт Мал үржлийн станцад шинээр сургууль төгсөж ирсэн мэргэжилтэн Л.Лхаасүрэн (Одоо МУ-ын гавьяат мал зүйч)-гийн санаачлагаар 1973 онд

Завхан аймгийн Тэс суманд, 1974 онд Баянтэс сумын бүх адуунд 24 үзүүлэлтээр шилэн сонголтыг хийж, шилмэл 854 адуугаар үржлийн ферм байгуулж, фермийн бүх адуунд ангийн им, тэмдэг, удмын нууц шивүүр тоог чихэнд нь хийж, биед нь аж ахуйн оноосон тамгыг дарж, бүрэн бүртгэлжүүлж анги чанарыг нь тогтоосон байгаа. Ийнхүү манай улсын монгол адууны анхны ферм байгуулсан байна. Эрүүл, 4-8 насны тарга хүч сайн, 2-3 сарын хээлтэй гүүний цусаар тарьж хээл авалт нь оройтсон үнээнүүдийн үнээний хээл авалтыг нэмэгдүүлэх зэрэг тэс адууг эдийн засгийн хувьд үр ашигтай ашиглаж байсан.

Мөн 1978 онд Увс аймгийн Тэс, Зүүнговь сумуудад Д.Самданжамц (МУ-ын гавьяат мал зүйч), зоотехникч Б.Ноост нарын санаачлагаар Тэс угшлын адуугаар дагнан үржлийн ферм байгуулж ойролцоо аймаг сумдад 1200 гаруй үржлийн адуу худалдаж нэгдлийн эдийн засгийг үр ашигтай ажиллах үндсийг тавьж байжээ. Дээрх ажлууд нь “Тэс” угшлын адуу нь хурд, уналга эдэлгээ, эрүүл үүлдэрлэг байдлаараа эртнээс танигдсан эдийн засгийн хувьд ашигтай өвөрмөц адуу учраас тусгайлан анхаарч хөгжүүлэх суурь болж өгчээ.

Материал, арга зүй

Судалгаанд шаардагдах суурь судалгаа, эрдэмтдийн хийсэн судалгаа шинжилгээний ажлын тайлан, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн зөвлөмжүүд, өрхийн орлого, зарлага, “Тэс” адууны тоо, түүхий эдийн зах зээлийн үнэ гэх мэт нарийвчилсан судалгаанд шаардлагатай мэдээллүүдийг ашиглан тооцооллыг хийж гүйцэтгэсэн. Судалгаанд үр ашгийн үндсэн суурь үзүүлэлтүүд болох 1 толгой малаас авах мах, сүү, арьс шир зэрэг орлогын, маллагаа, тэжээл, эм тарилга, цалин хөлс зэрэг зардлын, эмээл, хазаар, бугуйл зэрэг бусад үзүүлэлтүүдийг тооцоолж дүгнэлт өгсөн.

Судалгааны зорилго. Тэс адууг зах зээлд болон үржилд борлуулах, мах, дэл сүүл, арьс ширний

Судалгааны үр дүн

Улсын хэмжээнд адууны аж ахуйд үйлдвэрлэгдэж байгаа нийт мах, махан бүтээгдэхүүн (86,1 тэрбум төгрөг)-ний 2% буюу 1.722 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг Тэс угшлын адуу үржүүлж байгаа сумдад үйлдвэрлэгдэж байна. “Тэс” адууны амьдын жингийн дундаж нь азарга 40-50 кг, гүү 5-10 кг, нас гүйцсэн шүдлэн хязаалан 10-15 кг- аар Монгол болон Галшар үүлдрийн адуунаас илүү, мах үйлдвэрлэлээс олох орлого өндөр байх эдийн засгийн ашигтай байна. Хурдан морь уядаг өрхийн адууны аж ахуйгаас олж буй нийт орлогын 45.6%-ийг үржилд зориулан худалдсан адуу, 40%-ийг зах зээлд нядалж борлуулсан мах, 11.6%-ийг морин уралдаанаас олсон шагнал урамшуулал эзэлдэг. Галшар үүлдрийн адуутай өрхийн адууны аж ахуйгаас олох орлогын 51.7%-ийг шагнал болон үржилд зориулан худалдсан эзэлдэг бол тэс адуутай малчин өрхийн орлогын

Ерөнхий судалгаа

2018 оны эцсийн мал тооллогын дүнгээр улсын хэмжээнд 3940000 толгой адуу тоологдсон бөгөөд “Тэс” угшлын адуу үржүүлж байгаа сумдын нийт адууны тоо 107610 байгаа нь манай

арилжааны орлого, морины бай шагнал урамшуулал зэрэг бодит орлого, адууны уналга эдэлгээ даах чадвар, тэсвэр тэвчээртэй чанар, усч, зэрэг мөнгөн бус орлого зэргийг бусад үүлдэр, омгийн адуутай харьцуулж өрхийн аж ахуйн хувьд эдийн засгийн ашгийг тодорхойлох зорилготой судалгааны ажил юм.

Судалгааны объект. Тэс адууны эдийн засгийн засгийн үр ашгийн судалгааг нарийвчлан хийхийн тулд Увсын Тэс, Зүүнговь Завханы Тэс, Баянтэс, Хөвсгөлийн Цагаан-Уул, Цэцэрлэг сумдын 70 гаруй уяач малчдаас судалгаа, ярилцлага авч харьцуулалт хийсэн.

57.2%-ийг дээрх орлого бүрдүүлж байна. Тэс адууны 1 толгойгоос олж байгаа ашигт ажиллагааны төвшин 67% байгаа нь Монгол үүлдрийн адуунаас 10 %-иар илүү, Галшар үүлдрийн адуутай ижил төвшинд байна. Тэс адууны уналга эдэлгээний соёлыг дагасан эмээл, хазаар, бугуйл бусад тоног хэрэгслийн худалдаа арилжаа хөгжсөн нь бас эдийн засгийн ач холбогдолтой юм. Тэс адууг зах зээлд болон үржилд борлуулах, дэл сүүл, арьс ширний арилжааны орлого, морины бай шагнал урамшуулал зэрэг бодит орлого, адууны уналга эдэлгээ даах чадвар, тэсвэр тэвчээртэй чанар, усч зэрэг мөнгөн бус орлогыг бусад үүлдэр омгийн адуутай харьцуулахад өвөрмөц онцлогтой, өрхийн аж ахуйд нөлөөлөх харьцангуй эдийн засгийн илүү үр ашигтай адуу болох нь харагдаж байна.

улсын адууны **2.73 %** болж байна. Эндээс дүгнэж үзвэл улсын хэмжээнд адууны аж ахуйд үйлдвэрлэгдэж байгаа нийт мах, махан бүтээгдэхүүн (**86,1 тэрбум төгрөг**)-ний **2%** буюу **1.722 тэрбум** төгрөгийн бүтээгдэхүүнийг эдгээр сумдад үйлдвэрлэгдэж байна.

Table 1

Number of "Tes" horses

№	Сумдын нэрс	Адууны тоо /мян.тол/	Эзлэх хувь
1	Завхан Баянтэс	7.53	7.0
2	Завхан Тэс	7	6.5
3	Завхан Асгат	2.82	2.6
4	Завхан Баянхайрхан	6.27	5.8
5	Увс Зүүнговь	7.24	6.7
6	Увс Тэс	14.57	13.5
7	Завхан Баруунтуруун	6.75	6.3
8	Завхан Зүүнхангай	10.08	9.37
9	Хөвсгөл Цагаан-Уул	24.5	22.8
10	Хөвсгөл Цэцэрлэг	20.85	19.4
Нийт		107.61	100

Адууны аж ахуйн гол бүтээгдэхүүн нь уналга эдэлгээ байдаг. Харин Тэс адууны гол бүтээгдэхүүн нь хурдлах чадвар, уналга эдэлгээ, хүнсний хэрэглээ байх магадлалтай байна. "Тэс"

адууны эдийн засгийн ашгийг судлаачдын судалгааны ажлын үр дүн, ярилцлага, анкет судалгаа зэргийг үндэслэн тооцсон болно.

Table 2

"Tes" horses morphological body measures

Тэс омгийн адуу					Монгол үүлдрийн адуу						
№	Нас, хүйс	Мундааны өндөр, см	Цээжний бүслүүр, см	Биеийн ташуу урт, см	Амьдын жин, кг	№	Нас, хүйс	Мундааны өндөр, см	Цээжний бүслүүр, см	Биеийн ташуу урт, см	Амьдын жин, кг
1	Нас гүйцсэн азарга	135	168	138	360	1	Нас гүйцсэн азарга	130	165	136	360
2	Соёолон азарга	130	165	136	350	2	Соёолон азарга	128	163	133	340
3	Нас гүйцсэн гүү	132	163	134	340	3	Нас гүйцсэн гүү	125	160	130	320
4	Хязаалан байдас	128	160	130	280	4	Хязаалан байдас	122	150	128	290

Тэс адууны хувьд Монгол үүлдрийн адуутай харьцуулахад соёолон азарга, нас гүйцсэн гүүний амьдын жин, мөн адууны мундааны өндөр илүү

байгаа нь мах үйлдвэрлэл болон арьс ширний үйлдвэрлэлээс олох ашиг орлого илүү байх боломжтой.

Table 3

Horse's weight, kg

Үүлдэр, омог	Нас, хүйс					
	Азарга	Гүү	Хязаалан		Шүдлэн	
			эр	эм	эр	эм
Монгол үүлдрийн адуу	315-400	280-380	300	280	270	250
Галшар үүлдрийн адуу	370-410	290-380	300	290	275	250
Тэс омгийн адуу	360-450	320-360	310	290	280	260
Дархад омгийн адуу	340-400	320-380	315	280	275	260

Адууны амьдын жингийн стандартаас харахад Тэс омгийн адууны амьдын жингийн дундаж нь азарга 40-50 кг, гүү 5-10 кг, нас гүйцсэн шүдлэн хязаалан 10-15 кг-аар Монгол болон Галшар үүлдрийн адуунаас илүү байна. Энэ нь 1 малаас олох махны ашиг шим тэс адууных өндөр бөгөөд өрхийн аж ахуйн орлого нэмэгдүүлэх эдийн засгийн ач холбогдолтой юм.

Малчин өрхийн орлого зарлагын судалгаа

Тэс адууны эдийн засгийн үр ашгийг тодорхойлоход судлаачдын боловсруулсан адууны сүргийн эргэлтийн загварыг ашиглан 100 адуутай өрхийн сүргийн эргэлтийг тооцоолол хийж үзвэл сүргийн өвчлөл, зүй бус хорогдол,

гүүний хээл хаялт бага байдаг нь сүргийн нөхөн үйлдвэрлэлд эерэг нөлөөтэй байгааг харж болно. Энэ үр дүн нь үүлдэр батлах ажлын хүрээнд нутгийн малчид мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, тандан судалгаагаар батлагдсан.

Table 4

Horse farm income and expenditure calculation, 100 head

Нас хүйсний ялгаа	Толгойн тоо оны эхэнд	Орлого					Зарлага					Толгойн тоо оны эцэст	Сүргийн бүтэц %		
		Худалдаж авах	Төл	Нас дэвших	Бусад	Орлогын дүн	Зүй бус хорогдол	Үржилд	Маханд	Зах зээлд амьдаар борлуулах	Дотоод хэрэгцээ			Нас дэвшиж явах	Зарлагын дүн
Азарга	3	0				0	0	0	0	0	0	0	3	2.3	
Морь	25		4			4	1	0	3	1	1	0	23	17.69	
Гүү	35		6			6	1	0	1	1	0	0	38	29.23	
4 настай	эр	4		4		4	0	1	0	1	0	2	4	3.08	
	эм	6		5		5	0	0	1	0	0	5	6	3.85	
3 настай	эр	4		4		4	0	1	0	0	0	3	4	3.08	
	эм	5		5		5	0	0	0	0	0	5	5	3.85	
2 настай	эр	4		4		4	1	0	0	1	0	2	4	3.08	
	эм	5		5		5	0	1	0	0	0	4	5	3.85	
1 настай	эр	4		13		13	1	0	0	0	0	3	4	6.15	
	эм	5		13		13	1	0	0	0	0	4	5	7.69	
Төл	эр	0	13	0		0	0	0	0	0	0	0	0	0	
	эм	0	13	0		0	0	0	0	0	0	0	0	0	
Бүгд	100	0	26	63		63	4	3	5	4	1	28	42	101	100.0

Хэдийгээр Тэсийн голын ай сав газраар зундаа +30 градус, өвөлдөө -50 градус эрс тэс уур амьсгалтай хэдий ч адууны хувьд уур амьсгалдаа дасан зохицсон тэсвэртэй, уналга эдэлгээ даах чадвартай үүлдэрлэг байдал бий болсон нь өрхийн эдийн засгийн хувьд ашигтай юм.

Өрхийн орлогод зах зээлд болон үржилд зарцуулсан адуу, дэл сүүл, айраг, арьс ширний орлогоос гадна, наадмын урамшуулал зэргийг **бодит орлого** харин адууны уналга эдэлгээний зардал, хүнсэнд хэрэглэж буй айраг, махны орлогыг **бодит бус орлогод** оруулсан.

100 адуутай 5 ам бүлтэй айлын адууны аж ахуйн орлого, зарлагыг сүргийн эргэлтэд үндэслэн тооцоолоход нийт орлогын бүтэцэд малын худалдаа, маханд борлуулсны орлого дийлэнхийг эзэлж байна. Гүүний айраг саам хийх, худалдаалах уламжлал Тэс адуу үржүүлж байгаа сумдад байхгүйтэй холбоотой. Гэхдээ сүүлийн жилүүдэд аялал жуулчлал, эмчилгээ сувилгаа зэрэг чиглэлээр адууны аж ахуйгаас олох орлогын төрөл нэмэгдэж байна.

Сүргийн эргэлтэд тулгуурлан 100 адуутай малчин өрхийн орлого зарлагыг судалж үзвэл:

Table 5

Household income and expenditure estimates

Үзүүлэлтүүд		Тоо хэмжээ	Орон нутгийн дундаж үнэ/төг/	Дүн /төг/
Орлого	Маханд борлуулсан	4 толгой /720 кг/	4000	2880000
	Үржилд худалдсан	3 толгой	800000	2400000
	Сүү, цагаан идээ борлуулсан	0		0
	Дэл, сүүл	101 толгой	4000	484800
	Арьс, шир борлуулсны орлого	4 ш	15000	60000
	Толгой, гэдэс дотор	4 ш	8000	32000
	Бусад орлого			300000
	Бүгд орлогын дүн			9756800
Зарлага	Тэжээлийн зардал			500000
	Малын эм, тарилга			100000
	Бензин, шатахууны зардал			650000
	Удирдлагын зардал (Малчин өрхийн хэрэглээний зардал)			1400000
	Бусад зардал			600000
	Бүгд зардал			3250000
	Хуримтлагдсан ашиг (алдагдал)			6506800

100 адуутай өрхийн жилдээ олох орлого 6 сая гаруй төгрөг болж байгаа нь эдийн засгийн хувьд өрхийн амьжиргаанд нөлөөлөхүйц эерэг тал харагдаж байна. Нөгөө талаас Тэс адууны байгалийн эрсдэлтэй нөхцөлд дасан зохицсон

байдал нь тэжээлийн болон мал эмнэлгийн зардал бага гарах нөхцөл болж байна. Адууны аж ахуйн орлогын 93%-ийг мах болон амьд малын худалдаанаас, 7%-ийг бусад орлого бүрдүүлж байна. Үүнийг задалж харуулбал:



Figure 1. Household income

Сүргийн бүтэц дэх 100 толгой бүхий аж ахуйгаас олох орлогын 38%-ийг мах, 31%-ийг малын худалдаа, 25%-ийг үржлийн малын худалдаа,



Figure 2. Household income (Horseman)

5%-ийг дэл сүүл, 1%-ийг арьс шир, 0,3%-ийг дайвар бүтээгдэхүүнээс тус тус бүрдүүлж байна.



Figure 3. Income structure comparison

Хурдан морь уядаг өрхийн адууны аж ахуйгаас олж буй нийт орлогын 45.6%-ийг үржилд зориулан худалдсан адуу, 40%-ийг зах зээлд нядалж борлуулсан мах, 11.6%-ийг морин уралдаанаас олсон шагнал урамшуулал эзэлдэг бол бусад малчдын адууны аж ахуйгаас олж буй гол орлого нь зах зээлд борлуулж буй мал нядалгаанаас олсон орлого эзэлдэг ажээ. Энэ нь уг адууг нядалж борлуулахаас илүүтэй адууны хурдан байгаа шинж, уналга эдэлгээ дах чадварыг ашиглан орлого олж байгааг баталж

байна. Мөн сүүлийн үед гүүний төллөлтөөр гарсан эхэсийг 20000 төгрөгөөр авч бүтээгдэхүүн болгодог аж ахуй нэгж бий болж, төв суурингийнхан азарган үрээний хос засааг 15000 төгрөгөөр авч хэрэглэн биеийн чалх сайжруулах зэргээг ашиглаж байгаагаас адууны аж ахуйн үндсэн ба дайвар бүтээгдэхүүний орлого нэмэгдсээр байна. Дээрх судалгаануудад үндэслэн 1 малаас олж байгаа ашигт ажиллагааны төвшинг тооцоолж үзвэл:

Table 6

Profitability level			
	Орлого	Зарлага	ашиг
Тооцооны ашиг	97568	32500	65068
Ашигт ажиллагааны төвшин			67%

Адуун сүргийн эргэлт болон судалгааны үр дүнгээс харахад малчин өрхийн хувьд Тэс адууны 1 толгойгоос олж байгаа ашигт ажиллагааны төвшин 67% байгаа нь Монгол үүлдрийн адуунаас 10%-иар илүү, Галшар үүлдрийн адуутай ижил төвшинд байна.

“Тэс” адууны уналга эдэлгээ дагасан соёлын орлого

Адууны аж ахуйн нэг онцлог нь тооцооны болон эдийн засгийн хувьд ашиг олохоосоо илүүтэй малчдад, нийгэм соёлын хэрэгцээнд ашиглах хандлага илүү байна. Тэсийн гол дагуу орших малчид байгаль цаг уурын өвөрмөц онцлог,

уналга эдэлгээндээ зориулан эмээл, хазаар, бугуйл, гөлөм, ташуур зэрэг адууны эдлэл хэрэглэлийг хийж хэрэглэх, өөр хоорондоо арилжаалах нь адууны соёл дагасан орлогын томоохон эх үүсвэр юм. Тухайлбал ясан хяртай бүрэн тоноглолтой эмээлийн үнэ 1.5-5 сая төгрөг, Баядын хар суран бугуйл 250-500 мянган төгрөгөөр үнэлэгдэж байгаа нь Тэс адууны соёл дагасан орлого юм. Мөн адууны аж ахуй эрхлэхийн сацуу морины эдлэл хэрэглэл хийн орлого нэмэгдүүлж байгаа өрх Увсын Тэс, Завханы Баянтэс, Тэс, Хөвсгөлийн Цэцэрлэг, Цагаан уул сумдад цөөнгүй байна.

Дүгнэлт

1. “Тэс” адуу үржиж байгаа сумдын нийт адууны тоо 107610 байгаа нь улсын хэмжээнд адууны аж ахуйд үйлдвэрлэгдэж байгаа нийт мах, махан бүтээгдэхүүн (86,1 тэрбум төгрөг)-ний 2% буюу 1.722 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг эдгээр сумдад үйлдвэрлэгдэж байна.
2. Адууны амьдын жингийн стандартаас харахад Тэс адууны амьдын жингийн дундаж нь азарга 40-50кг, гүү 5-10кг, нас гүйцсэн шүдлэн хязгаалан 10-15кг-аар Монгол болон Галшар үүлдрийн адуунаас илүү байна. Энэ нь мах үйлдвэрлэлээс олох орлого өндөр байх эдийн засгийн үр ашигтай байна.
3. Хурдан морь уядаг өрхийн адууны аж ахуйгаас олж буй нийт орлогын 45.6%-ийг үржилд зориулан худалдсан адуу, 40%-ийг зах зээлд нядалж борлуулсан мах, 11.6%-ийг морин уралдаанаас олсон шагнал урамшуулал эзэлдэг. Галшар үүлдрийн адуутай өрхийн адууны аж ахуйгаас олох орлогын 51.7%-ийг шагнал болон үржилд зориулан худалдсан орлого эзэлдэг бол тэс адуутай малчин өрхийн орлогын 57.2%-ийг дээрх орлого бүрдүүлж байна.
4. Тэс адууны 1 толгойгоос олж байгаа ашигт ажиллагааны төвшин 67% байгаа нь Монгол үүлдрийн адуунаас 10%-иар илүү, Галшар үүлдрийн адуутай ижил төвшинд байна.
5. Байгалийн эрс тэс уур амьсгалтай газар нутагт дасан зохицох чадвар өндөр тул уналга эдэлгээ, усч, тэсвэр тэвчээрээр илүү өвчлөл бага байгаа нь өрхийн аж ахуйн хувьд ач холбогдол өндөртэй. Үүнийг нийт судалгаанд хамрагдсан малчдын 96% нь хариулсан байна.
6. Мөн адууны зүй бус хорогдол, гүүний хээл хаялт бага байгаа нь тухайн газар нутагт дасан зохицсон, өрхийн орлогыг тогтвортой болгох эрсдэл бага аж ахуй болох нь харагдаж байна. Малчид, мэргэжилтнүүдтэй үүлдрийн хянан магадлагааны үеэр хийсэн ярилцлагын явцад нотлогдож байна.
7. Тэс адууны уналга эдэлгээний соёлыг дагасан эмээл, хазаар, бугуйл бусад тоног хэрэгслэлийн худалдаа арилжаа хөгжсөн нь эдийн засгийн ач холбогдолтой юм.
8. Тэс адууг зах зээлд болон үржилд борлуулах, дэл сүүл, арьс ширний арилжааны орлого, морины бай шагнал урамшуулал зэрэг бодит орлого, адууны уналга эдэлгээ даах чадвар, тэсвэр тэвчээртэй чанар, усч зэрэг мөнгөн бус орлогыг бусад үүлдэр омгийн адуутай харьцуулахад өвөрмөц онцлогтой, өрхийн аж ахуйд нөлөөлөх харьцангуй илүү эдийн засгийн үр ашигтай адуу болох нь харагдаж байна.

Талархал

Судалгааны ажлыг хийхэд хамтран ажилласан Тэс угшлын адууг үржүүлж байгаа Увс аймгийн Тэс, Зүүнговь, Завхан аймгийн Тэс, Баянтэс, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул сумдын

малчид, орон нутгийн удирдлагууд, Тэс адууны хянан магадлагааны ажлын хэсгийн хамт олонд талархал илэрхийлье.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Монгол мал үндэсний хөтөлбөр. УБ, 2010 он
2. Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс бодлогын баримт бичиг. УБ, 2010 он
3. Нүүдэлчин сэтгүүл УБ, 2018
4. Чойжилжав Х., Самданжамц Д., Батаа.Б, Монголын морин уралдаан 2014
5. ХАА-н Фермерийн аж ахуйн менежмент, УБ, 2018 он

Economic efficiency of the “Tes” horse

Yadmaa Zandan* 

School of Economics and Business, Mongolian University of Life Sciences, Zaisan 17024, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: yadmaa.z@mul.edu.mn

 <https://orcid.org/0000-0002-8374-5555>

Received: 01.10.2021

Revised: 07.12.2021

Accepted: 31.12.2021

Abstract

The “Tes” horse, developed mainly through natural selection, is strong enough to survive long and severe subzero spells. The “Tes” horses live outdoors all year at 30 °C (86 °F) in summer down to –50 °C (–40 °F) in winter, and search for food on their own. Strong, fast and hardy, the “Tes” horse is the lord of the steppe. The main stock of Tes horse breed is now kept in Tes and Zuungovi soum of Uvs province, Tes and Bayantes soum of Zavkhan province, Tsetserleg and Tsagaan-uul soum of Khuvsgul province of Mongolia. The profit margin per head of Tes horses is 67%, which is 10% higher than that of “Mongol” horses and at the same level as that of “Galshar” horses, as calculated by research team in 2019. The average live weight of “Tes” horses is 40-50 kg for stallions and 5-10 kg for mares, which is higher than “Mongol” and “Galshar” horses. It is economically viable for meat production.

Keywords: breed, income, expense, “Galshar” breed